

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-3
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	4-53
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	54-102
<i>1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	55-57
<i>2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	57-59
<i>3.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	59-60
<i>4.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах</i>	60-63
<i>5.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	63-67
<i>6.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	67-69; 73-80
<i>7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	69-70 89-91
<i>8.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	70-71; 80-81;
<i>9.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн</i>	

<i>төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	71-72
<i>10.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	72
<i>11.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	72-73
<i>12.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өдөр мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	73
<i>13.Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	91-102

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 04 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Болорчулуун, Ц.Мөнхцэцэг;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Ц.Анандбазар, П.Анужин, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ж.Сүхбаатар, Ц.Туваан, Ц.Цэрэнпунцаг, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, С.Батболд, Ш.Раднаасэд;

Тасалсан: А.Адъяасүрэн, Н.Ганибал.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Хуралдаан даргалагч Байнгын хороодын хуралдаан хуралдаж байгааг мэдэгдэж, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх, үргэлжлэл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх, үргэлжлэл, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг түр хойшлуулав./15.07/

Нэг.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, мөн газрын дэд дарга Д.Тэмүүлэн, Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ууганбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Ариунаа, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу түр хойшлуулав./15.13/

***Хоёр.**Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч ажлын хэсгийн гишүүд байхгүй байгааг мэдэгдэж, уг асуудлыг түр хойшлуулав./15:24/

***Гурав.**Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу түр хойшлуулав./15:20/

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.

Дөрөв.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:25/

Дагалдан гарсан:

2.Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:25/

3.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:25/

4.Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

5.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

7.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн

найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

8.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

9.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:26/

10.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

11.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

12.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

13.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

14.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./14:36/

Дагалдан гарсан:

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:27/

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:28/

4.Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:28/

5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:28/

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:28/

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:28/

Дагалдан гарсан:

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

4.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

5.Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

1.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын

Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

Дагалдан гарсан:

2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

3. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

4. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

8. Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

11.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

12.“Хуулийн төсөл буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаад Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:44/

Хуралдаан даргалагч Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг түр хойшлуулав./15:51/

Зургаа.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх

Л.Батмөнх, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Хуралдаан даргалагч ажлын хэсэг байхгүй байгааг мэдэгдэж, уг асуудлыг түр хойшлуулав./15:57/

Долоо.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:05/

Найм.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг түр хойшлуулав./16:08/

Ес.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	20
Бүгд:	39

48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	18
Бүгд:	39

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16

Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Арваннэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Арванхоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өдөр мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 60

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, *Нийслэлийн Засаг даргын* Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.3 дахь заалтын “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийн ААНОАТ-ыг 5 хувь болгоно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.16 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Ховдын Дөргөн”-“Завханы Загастайн даваа”-ны урд яруугийн уулзвар чиглэлийн 375 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Ховд, Завхан) гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “3,187.50” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	20
Бүгд:	40

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 2000 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “17,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	25
Бүгд:	40

37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.19 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 200 км авто зам барих (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	29
Бүгд:	40

27.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.17 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Алтай-Бургастай боомт чиглэлийн 253 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “101,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	29
Бүгд:	40

27.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Хожуулын голын гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “7,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 25

Бүгд: 40

37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.21 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Идэр голын 96 у/м төмөрбетон гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “8,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 26

Бүгд: 40

35.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.22 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “5,040.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 21

Бүгд: 41

48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Байдрагийн усан цахилгаан станц барих (Баянхонгор аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “30” гэж, Санхүүжилтэд “54,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Авто замын засвар арчлалтын ажилд шаардлагатай асфальтбетон завод, тоног төхөөрөмж худалдаж авах /Улсын хэмжээнд/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Тоног, төхөөрөмж” гэж, Хэмжих нэгжид “тоо” гэж, Суурь түвшинд “4” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “4,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	22
Бүгд:	40

45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газрын барилга барих” Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	25
Бүгд:	40

37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.6. дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Үндэсний хиймэл дагуулын дэд бүтцийг байгуулах” гэснийг “Монгол Улсын Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Төслийн хэрэгжилт” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэснийг “75” гэж, Санхүүжилтэд “1,600.00” /Нэг тэрбум зургаан зуун сая/ гэснийг “568,716.33” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний нөөцийн аудитын ажлыг сайжруулах, ёс зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Төрийн албаны зөвлөл” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	21

Бүгд: 40
47.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх” гэснийг “Эмээлт Эко Аж Үйлдвэрийн паркийн дулаан болон цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Цахилгаан хангамжийн барилгын ажлын гүйцэтгэл” гэснийг “Ажлын гүйцэтгэл” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэснийг “25” гэж, Санхүүжилтэд “14,800.00” гэснийг “112,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “85,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншлэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 24
Бүгд: 40
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Туул усан цогцолбор барих төслийг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “426,740.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншлэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 23
Бүгд: 40
42.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Гадаадын тусламж, Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 21
Бүгд: 40
47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Сэргээгдэх эрчим хүч бүхий дулаан автобусны буудал барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “9,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 23
Бүгд: 40
42.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Гэр хорооллын далан дагуух авто зам төсөл хэрэгжүүлэх /Баянгол дүүргийн 21, 9, 10, 22 дүгээр хороо/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 25
Бүгд: 40
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.3.3.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Баянгол дүүргийн Цагдаагийн газрын барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “13,000.00”

гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 23
Бүгд: 40
42.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах” гэснийг “Хавдар судлалын Үндэсний төв-II-ийн дэд бүтэц барилгын ажлыг эхлүүлэх” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэснийг “110,000.00” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.7 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 29
Бүгд: 40
27.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Улсын төсөв” гэснийг “Төр

хувийн хэвшлийн түншлэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Яаралтай тусламжийн төв барих (Орхон аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “5,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.8 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Өрх, гэр эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Булган аймаг)” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж, мөн заалтын Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Хөвсгөл аймаг)” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 24
Бүгд: 39
38.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.8 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Өрх, гэр эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Булган аймаг)” гэж, Хэмжих нэгжид

“Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж, мөн заалтын Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Хөвсгөл аймаг)” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.19 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд ““Мөрөн-Улиастай” чиглэлийн хатуу хучилттай авто зам төсөл барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “10” гэж, Санхүүжилтэд “43,590.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 21
Бүгд: 39
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.3 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэнд хуульчдыг мэргэшүүлэх”, гэж, Шалгуур үзүүлэлтэд “Мэргэшүүлэх хуульчдын тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “1,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ХЗДХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

4/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг ашиглаж үр дүнг хангахад чиглэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Найруулгын санал

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 20
Бүгд: 37
45.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17

Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1 дэх хэсэг, 6.1.5, 6.2.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хүн”, “хүний”, “хүнийг” гэснийг тухай бүрд “иргэн”, “иргэний”, “иргэнийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг тус тус хасаж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахаас сэргийлэх” гэснийг “үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “айлчилж байгаа” гэсний дараа “болон Монгол Улсын

нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалтыг доор дурдсанаар 6.2.6, 6.2.7 болгон өөрчлөн найруулах:

“6.2.6.энэ хуулийн 6.1.6-д заасан зочин айлчлах болон дамжин өнгөрөх хугацаанд;

6.2.7.энэ хуулийн 6.1.7-д заасан зочин айлчлах хугацаанд болон хүсэлт гаргавал Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хугацаанд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллага” гэснийг хасаж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 7.2-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “барилга байгууламж” гэснийг “барилга, бусад зүйл” гэж, мөн хэсгийн болон 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “маршрутын” гэснийг “чиглэлийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь хэсгийн “маршрут” гэснийг “чиглэл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж өөрчилж, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Олон улсын дээд хэмжээний уулзалт, хурлыг төрийн тусгай хамгаалалтад авахад шаардагдах зардлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.5.Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх бусад зүйлийн жагсаалтыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “байж болно” гэснийг “байна” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “бусад хүн” гэснийг “бусад этгээд” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хүн” гэснийг “аливаа этгээд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь хэсгийг нэгтгэж, 13.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Хамгаалалтын дэглэмээр тодорхой эд зүйл нэвтрүүлэхийг хориглох, зорчих хөдөлгөөн болон тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, түр зогсоох, хяналтын дэг журам тогтоох зэрэг бусад үйл ажиллагааг явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг болон 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг нэгтгэж, 14.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасан урьдчилан сэргийлэх, хамгаалалтын техникийн, орчны болон эрүүл ахуйн үзлэг хийх журам, зааврыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “олон улсын дээд хэмжээний” гэсний дараа “уулзалт,” гэж нэмж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хамгаалалт найдвартай байхад чиглэсэн” гэснийг “хамгаалалтын бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 17
 Бүгд: 39
 56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “байгууламж,” “найдвартай” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “барилга байгууламжийг” гэснийг “барилгыг” гэж, 17.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “барилга байгууламжийн” гэснийг “барилга, бусад зүйлийн” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ХҮЛЭЭХ ҮҮРЭГ” гэснийг “ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ” гэж, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлийн гарчгийн “үүрэг” гэснийг “чиг үүрэг” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх” гэснийг “хэрэгжүүлэх чиг үүрэг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Төрийн тусгай хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд төрийн бусад байгууллага энэ хууль болон холбогдох хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлэн оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 17
 Бүгд: 39
 56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “эрүүгийн” гэсний дараа “болон хэв журмын талаар” гэж нэмж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчин болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналт тавьж, лабораторийн шинжилгээ хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19
 Бүгд: 39
 51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “ашгийн төлөө бус” гэснийг “төрийн бус” гэж, 24.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, ашгийн төлөө бус байгууллага” гэснийг “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
 Татгалзсан: 18
 Бүгд: 39
 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал зөвлөгөөг тусгаж ажиллана” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын байгууллагад урьдчилан мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал, зөвлөгөөг тусгаж хамтран ажиллана” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
 Татгалзсан: 18
 Бүгд: 39
 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “үзүүлж хамтран ажиллана” гэснийг “үзүүлэх үүрэг хүлээнэ” гэж өөрчилж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “хуульд заасан хүрээнд зохион байгуулж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
 Татгалзсан: 18
 Бүгд: 39
 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийг 28 дугаар зүйлтэй нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг

27.1. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1. төрийн тусгай хамгаалалтыг зохиох, хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах;

27.1.2. төрийн тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийг хамгаалах;

27.1.3.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;

27.1.4.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

27.1.5.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиглүүлэх;

27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, энэ хуульд заасан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

27.1.7.энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан болон иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;

27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;

27.1.9.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

27.1.10.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчид Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

27.1.11.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлд лабораторийн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;

27.1.12.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсэд радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;

27.1.13.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан хамтран ажиллах;

27.1.14.төрийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийн санд нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;

27.1.15.төрийн тусгай хамгаалалтыг далд хэлбэрээр хэрэгжүүлэхдээ өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;

27.1.16.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;

27.1.17.гадаад улсын төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

27.1.18.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;

27.1.19.энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийг өргөө, зориулалтын орон сууц, үйлчлэх бүрэлдэхүүн, эдийн болон хүнсний бүтээгдэхүүнээр хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, өргөө, зориулалтын орон сууцны ашиглалтын техникийн бэлэн байдлыг хариуцах;

27.1.20.хамгаалуулагчид зориулалтын тээврийн хэрэгсэл, тусгай холбоогоор үйлчлэх;

27.1.21.төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд холбогдох байгууллагатай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

27.1.22.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм сахиулах, халдлага, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

27.1.23.чиг үүргийнхээ хүрээнд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

27.1.24.үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

27.1.25.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах;

27.1.26.байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

27.1.27.хуульд заасан бусад” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээд” гэснийг “бусад этгээд” гэж

өөрчилж, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 32.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “биелэлтийг хангуулах” гэснийг “мөрдүүлэх” гэж, 32.1.10 дахь заалтын “мэдлэг чадварыг” гэснийг “мэдлэг, ур чадварыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 32.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.7.төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг дотоод, гадаадад төлөөлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Энэ хуульд заасан” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн” гэж, “албан хаагч байна” гэснийг “албан хаагч мөн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 33.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.4.Шадар хамгаалалтын ажилтан нь төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсгийн “алба хаагч нь байгууллагаас олгосон албаны үнэмлэхтэй байх ба” гэснийг хасаж, 35.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.8.Аливаа этгээд төрийн тусгай хамгаалалтын албаны дүрэмт хувцас, үнэмлэхийг хэрэглэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 33.2-т” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “энэ хуулийн 11.4-т заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.3.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 17
 Бүгд: 39
 56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын “холбоотой” гэсний дараа “хууль ёсны” гэж, мөн зүйлийн 37.1.6 дахь заалтын “эд зүйлд” гэсний өмнө “бие болон” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
 Татгалзсан: 19
 Бүгд: 40
 52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.1 болон 38.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.1.өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 18
 Бүгд: 40
 55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтын “явахгүй” гэсний, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “тавихгүй” гэсний дараа “байх” гэж тус тус нэмж, 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтыг 38.1.7 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.7.өөрийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжил, мэргэшил, албаны бэлтгэлийн түвшинг хадгалах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 18

Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “холбогдон” гэснийг хасаж, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалтын “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг хасаж, 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, буцах замд явах болон энхийг дэмжих ажиллагаанд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэмт халдлагын улмаас” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Төрийн ордон нь төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7.7 дахь хэсгийг нэмэх:

“7.7.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж энэ хуулийн 3.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.8 дахь хэсгийн “дарга болон дотоодын цэргийн командлагчийн” гэснийг “даргын” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйлчилгээ явуулах болон засвар” гэсний өмнө “ордонд” гэж, “үйлчилгээний тусгай” гэсний өмнө “ордны” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

**Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны
дэмжсэн санал:

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “Сонгуулийн сурталчилгааны” гэсний өмнө “Нэгээс илүү сувагтай радио, телевиз нь” гэж нэмж, 37 дахь хэсгийн “нэр дэвшигч оролцсон” гэсний дараах “, эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	18
Бүгд:	40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	18
Бүгд:	40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	21
Бүгд:	40

47.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
-------------	----

Татгалзсан: 18
 Бүгд: 40
 55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 18
 Бүгд: 40
 55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 17
 Бүгд: 40
 57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 17
 Бүгд: 40
 57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 17
 Бүгд: 40
 57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Пүрэв гараг хүртэл хэлэлцэхийг түр хойшлуулах санал гаргаж, Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн *Д.Тогтохсүрэнгийн* гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 18
 Бүгд: 40

55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, *Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Пүрэв гараг хүртэл хэлэлцэхийг түр хойшлуулж, Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхээр тогтов. /18:40/*

Арвангурав.Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Э.Тэмүүжин, мөн хорооны ажлын албаны хуульч Б.Өлзийбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, мөн хорооны эрдэмтэн, судлаач П.Жаргалсайхан, судлаач Х.Бакытжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, А.Адъяасүрэн, Т.Аубакир, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “сэтгэл оюуны болон” гэснийг, мөн заалтын “үүний үр дүнд оюун ухааны болон” гэснийг, 4.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг, мөн заалтын “биеийн тамир багш, дасгалжуулагч, арга зүйчийн мэргэжлээр” гэснийг, 4.1.16, 4.1.31 дэх заалтын “дунд зохион байгуулах” гэснийг, 4.1.17 дахь заалтын “дүрэм, журмыг” гэснийг, 4.1.22 дахь заалтын “үндсэн дээр мөнгөн урамшуулал авахгүйгээр” гэснийг, 4.1.30 дахь заалтын “зэрэг үндэсний уламжлалт спортыг” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4.1.11, 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11.“идэвхтэй хөдөлгөөн” гэж эрүүл мэнд, бие бялдрыг дэмжихэд чиглэсэн хүний булчингийн үйл ажиллагааг 30 минутын хугацаанд идэвхтэй ажиллуулах дасгал хөдөлгөөнийг;

4.1.18.“спорт” гэж биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэн, тэмцээн, наадамд тусгай журмын дагуу бэлтгэж оролцох үйл ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	19
Бүгд:	40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “дэмжих замаар нийгэмд эерэг хандлагыг дэлгэрүүлэх үйлсэд” гэснийг “дэмжихэд” гэж өөрчилж, мөн заалтын “хичээллэх,” гэсний дараа “спортын” гэж, 5.1.6 дахь заалтын “хүүхдийг” гэсний өмнө “эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21
 Бүгд: 40
 47.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
 Татгалзсан: 21
 Бүгд: 40
 47.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 17
 Бүгд: 40
 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “дэмжих замаар нийгэмд эерэг хандлагыг дэлгэрүүлэх үйлсэд” гэснийг “дэмжихэд” гэж өөрчилж, мөн заалтын “хичээллэх,” гэсний дараа “спортын” гэж, 5.1.6 дахь заалтын “хүүхдийг” гэсний өмнө “эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
 Татгалзсан: 18
 Бүгд: 40
 55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хүндлэл” гэснийг, мөн заалтын “мөн чанарыг эрхэмлэх зэрэг” гэснийг, 7.1.6 дахь заалтын “иргэн болон өөр хоорондоо хүндэтгэлтэй, эелдэг харьцаж,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 7.1-д заасан этгээд ёс зүйн зөрчил гаргасан бол Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ёс зүйн шийтгэл хүлээх хугацаанд мөнгөн шагнал, урамшуулал олгохыг түр түтгэлзүүлэх шийдвэрийг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 17
 Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “олон улсын” гэснийг хасаж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “улсын” гэсний өмнө нэмж, мөн заалтын “, тэмцээнийг санхүүжүүлэх журам батлах” гэснийг хасаж, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж, 10.1.7 дахь заалтын “байгууллага” гэсний дараа “биеийн тамир, спортын” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.9 дэх заалт нэмэх:

“10.1.9.улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах журам батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “хэрэгжилтийг зохион байгуулах,” гэснийг, 11.1.7 дахь заалтын “холбогдох бусад” гэснийг, 11.1.10 дахь заалтын “шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих,” гэснийг, мөн заалтын “хэрэгжилтийг” гэснийг, 11.1.11 дэх заалтын “энэ хуулийн 9.1.3-т заасныг үндэслэн” гэснийг, мөн заалтын “үйл ажиллагаанд” гэснийг, 11.1.12 дахь заалтын “нэгдсэн бодлого” гэснийг, 11.1.13 дахь заалтын “ажилтан” гэснийг, 11.1.16 дахь заалтын “сургалтын орчныг сайжруулах зөвлөмж гаргах” гэснийг, 11.1.21 дэх заалтын “ажлыг зохион байгуулах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 11.1.10 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “журмын дагуу” гэж, 11.1.11 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 11.1.16 дахь заалтын “хэрэгжүүлэхэд” гэснийг “боловсруулахад санал өгөх” гэж, 11.1.19 дэх заалтын “ажлыг зохион байгуулах” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах;” гэж, 11.1.20 дэх заалтын “уралдаан тэмцээнд” гэснийг “наадамд” гэж, 11.3 дахь хэсгийн “нэгжтэй” гэснийг “салбар байгууллагатай” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 11.1.4, 11.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.хүн амын бие бялдрын түвшин тогтоох, сорилын үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлал, боловсруулах;

11.1.18.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хороо байгуулж ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх хуулийн этгээдийг байгуулах тухай шийдвэр гаргах” гэснийг хасаж, мөн заалтын “дэлхийн зэрэглэлийн” гэснийг “дэлхийн аварга шалгаруулах тэмцээн,” гэж, 12.1.6 дахь заалтын “аймаг, дүүргийн өсвөр үе, оюутны шигшээ багийн төсөв батлах” гэснийг “санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 12.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.5.аймаг, нийслэл, дүүргийн өсвөр үе, оюутны шигшээ багт нийслэл, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөв батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үеийн шигшээ багт, нийслэлийн төсвөөс оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.6, 14.1.7 дахь заалтын “ажилтан” гэсний өмнө “байгууллагын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн” гэснийг хасаж, 14.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.5.байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан ажилтантай байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “мэргэжлийн” гэсний дараа “техникийн” гэж нэмж, мөн заалтын “боловсролын” гэснийг “ердийн болон эмчилгээний биеийн тамирын сургалтын” гэж, 16.1.2 дахь заалтын “гадуурх ажлын чиглэлийг тогтооход” гэснийг “бусад сургалт явуулахад” гэж, 16.2.6 дахь заалтын “ерөнхий эрдмийн хичээлийн сургалтын чанарын үнэлгээ хангасан суралцагчийг” гэснийг “суралцагчийн сурлагын үнэлгээг харгалзан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 16.1.4 дэх заалтын “асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх” гэснийг, 16.2.6 дахь заалтын “зохион байгуулагдаж байгаа” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 16.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.4.боловсролын байгууллага нь сургалтын хөтөлбөрөөс гадна спорт клубийн хэлбэрээр суралцагчдын дунд үйл ажиллагаа зохион байгуулж болно;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “чиглэлийн” гэснийг, 17.1.3 дахь заалтын “хамтран” гэснийг, 17.2.1 дэх заалтын “ажил” гэснийг, 17.2.2 дахь заалтын “физик” гэснийг тус тус хасаж, 17.2.2 дахь заалтын “спортын ажилтны оролцоотойгоор зохион байгуулах” гэснийг “арга зүйчтэй хамтран ажиллах” гэж өөрчлөн, 17.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.2.хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад сэргээн засах тусламж, үйлчилгээ, эмчилгээний биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр хүний эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “түвшний” гэснийг болон “, тамирчинд зориулсан” гэснийг, 20.2 дахь хэсгийн “өөр өөрийн онцлогт тохирсон” гэснийг, 20.5 дахь хэсгийн “өөрийн төлөөлөгчийн газар,” гэснийг, 20.6 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн тухайн” гэснийг, 20.8.15 дахь заалтын “, дэмжлэг авах” гэснийг, 20.9 дэх хэсгийн “дэмжлэгийн хэмжээ,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 20.4 дэх хэсгийн “өөрийн онцлог байдал, үйл ажиллагааны чиглэлээр нэг спортын төрлийн нэг төлөөлөгчийн газар,” гэснийг “онцлогт тохирсон нэг төрлийн спортын” гэж, 20.9 дэх хэсгийн “дэлхийн зэрэглэлийн” гэснийг “дэлхийн аварга шалгаруулах” гэж, мөн хэсгийн “15” гэснийг “10” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.8.14 дэх заалт нэмэх:

“20.8.14.спортын төрлийн үйл ажиллагаа, сургалт, дасгалжуулалт, орчны стандартыг боловсруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрлийн” гэснийг, 21.4 дэх хэсгийн “15 хүртэлх хүүхэд тутамд нэг” гэснийг тус тус хасаж, 21.3 дахь хэсгийн “эрүүл мэндийн байдалд” гэсний дараа “мэргэжлийн байгууллагын” гэж нэмж, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийн “үндэсний стандарт байхгүй” гэснийг “мөрдөх боломжгүй” гэж, 21.4 дэх хэсгийн “хангаж” гэснийг “хариуцан ажиллана” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Спортын клуб нь иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхлэн, сургалт, дасгалжуулалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, ёс зүйтэй, хүмүүнлэг, бүтээлч, эрүүл чийрэг иргэн бэлтгэх, эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “бололцоогоор хангах” гэсний дараа “тухайн сургуулийн” гэж нэмж, мөн зүйлийн 23.4, 23.5, 23.6, 23.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.4.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хууль болон энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн холбоотой гэрээ байгуулж, санхүүжүүлнэ.

23.5.Аймаг, дүүргийн Засаг дарга спортын 10-аас доошгүй төрлөөр өсвөр үеийн шигшээ багийг байгуулан, орон нутаг дахь спортын холбоотой хамтран сонгон шалгаруулж, орон нутгийн төсвөөс үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

23.6.Нийслэлийн Засаг дарга оюутны дэлхийн аварга, дэлхийн оюутны спортын наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох оюутны шигшээ багийг спортын 8-аас доошгүй төрлөөр байгуулж, санхүүжүүлнэ.

23.8.Ёс зүйн болон допингийн зөрчил гаргасан нь шигшээ багийг бүрдүүлж байгаа спортын холбоо, тамирчин, дасгалжуулагчийг санхүүжүүлэхгүй байх үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 25.8 дахь хэсгийн дугаарыг 25.6 болгон “зохион байгуулагч” гэсний дараа “, спортын холбоо, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь” гэж, 25.7 дахь хэсгийн “тэмцээний үед” гэсний өмнө “Зохион байгуулагч, спортын холбоо” гэж тус тус нэмж, мөн заалтын “эрүүл мэндэд хохирол учирсан” гэсний хасаж, 25.8 дахь хэсгийн “таслан зогсоох” гэснийг “гэнэтийн ослын даатгалд хамруулах, аюулгүй байдлыг хангах” гэж өөрчлөн, мөн зүйлийн 25.4, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.4.Энэ хуулийн 25.3-т заасан хуваарьт тусгагдаагүй спортын тэмцээнийг зохион байгуулагч тухайн сум, дүүрэг, хорооны биеийн тамирын арга зүйч, Биеийн тамир, спортын газарт ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

25.6.Энэ хуулийн 25.3, 25.4-т заасан спортын тэмцээнийг урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд зохион байгуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “чиг үүргийг” гэсний дараа “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.4, 27.1.5 дахь заалт, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8 дахь хэсэг тус тус нэмэх:

“27.1.4.Допингийн эсрэг үндэсний зөвлөл;

27.1.5.Монголын олон улсын ба үндэсний спортын арбитр;

27.4.Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу Монголын үндэсний олимпын хороо Допингийн эсрэг үндэсний байгууллагыг үүсгэн байгуулах эрхтэй.

27.5.Допингийн эсрэг үндэсний байгууллагын удирдах зөвлөл нь 13 хүртэл тооны сондгой гишүүнтэй байх бөгөөд Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хороо, биеийн тамир, спортын салбарын төрийн байгууллага, спортын холбоо, тамирчдын зөвлөл, хуульчдын холбоо, эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

27.6.Допингийн эсрэг үндэсний байгууллага нь Дэлхийн допингийн эсрэг агентлагийн Допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлын тухай удирдамжийн холбогдох заалт, Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн¹ дагуу ил тод байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана.

27.7.Допингийн эсрэг үндэсний байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаатай нэг удаа сонгоно.

27.8.Монгол Улсын Засгийн газар Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцын дагуу хүлээсэн үүргээ энэ хуулийн 27.1.4-т заасан Допингийн эсрэг үндэсний зөвлөлөөр төлөөлүүлэн хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “27.4” гэснийг “27.3” гэж өөрчлөн, мөн зүйлийн 28.3.2 дахь заалтын “нэр дэвшигчийг” гэсний дараа “Дэлхийн допингийн эсрэг агентлагийн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.2 дахь хэсэг нэмэх:

“28.2.Допингийн эсрэг үндэсний байгууллагын үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлсэн, эсхүл татан буугдсан бол энэ тухай Дэлхийн допингийн эсрэг агентлагт мэдэгдэж, тус байгууллагыг шинэчлэх, дахин шинээр байгуулах хүртэл түүний үүргийг Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрмийн дагуу Монголын үндэсний олимпын хороо түр орлон гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “Пара спорт, дүлий иргэдийн спорт, оюун ухааны” гэснийг хасаж, мөн хэсгийн “холбоо,” гэсний дараа “спорт клуб” гэж нэмж, мөн зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэмжлэг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
 Татгалзсан: 16
 Бүгд: 39
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалтын “бие сэтгэцийн хөгжилд тодорхойлолт” гэснийг “бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн онцлогт үнэлэлт, дүгнэлт” гэж өөрчилж, мөн зүйлийн 31.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах болон мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4.8 дахь заалт нэмэх:

“31.2.Дасгалжуулагч энэ хуулийн 9.1.5-д заасан журмын дагуу олгогдсон мөнгөн шагнал хүртсэн тамирчны мөнгөн урамшууллаас талуудын гэрээний дагуу тодорхой хувь хүртэнэ.

31.4.8.допингийн талаарх мэдлэг, мэдээллээ байнга шинэчлэх, суралцагч, тамирчдад допинг хэрэглэхгүй байхыг зөвлөх, допингийн эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
 Татгалзсан: 14
 Бүгд: 39
 64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “хөдөлмөрийн” гэсний дараа “хүнд” гэж нэмж, мөн заалтын “гүйцэтгэсэн хөдөлмөрийн чанар, хэмжээнд” гэснийг “ажил үүрэгтээ” гэж өөрчилж, 33.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 33.2.2, 33.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.2.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдал, долоо хоногийн амралтын өдөр ажиллаж, нөхөн амруулаагүй бол Хөдөлмөрийн тухай хуулийн 109.2-т заасан нэмэгдэл цалин хөлсийг олгох, бусад урамшуулал, дэмжлэг үзүүлэх;

33.2.3.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн биеийн тамир, спортын байгууллагын биеийн тамир спортын ажилтан, арга зүйч, дасгалжуулагчид 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “22.3,” гэснийг “, 22.3-г заасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Спортыг дэмжих сангаас” гэж, 34.6 дахь хэсгийн “төсөвт бие даасан зүйл болгон батална” гэснийг “төсвөөс” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “спортын” гэсний өмнө “Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж нэмж, 37.7 дахь хэсгийн “ажиллуулах” гэснийг “хадгалах, хамгаалах, ашиглах, түгээх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “хяналтын” гэсний дараа “үйл ажиллагааг” гэж, 39.3 дахь хэсгийн “тохиролцсон,” гэсний дараа “эсхүл спортын холбоод, тамирчин, дасгалжуулагч, сонирхогч этгээд хүсэлт гаргасан бол” гэж, мөн хэсгийн “холбоотой” гэсний дараа “аливаа” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 39.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.2 дахь хэсэг нэмэх:

“40.2.Олимп, тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн этгээд эрүүгийн хариуцлага хүлээсэн бол сар бүрийн

мөнгөн урамшууллыг ял шийтгэл эдлэх хугацаанд нь олгохыг зогсооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.8.спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих, олон улсын спортын холбооны стандартад нийцсэн, олимп, тив дэлхийн тэмцээн зохион байгуулах, спортын барилга байгууламжийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд өгсөн 100 сая хүртэлх төгрөгийн хандив;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “40.7” гэснийг “40.10” болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасаж, 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хичээллэх” гэсний дараа “идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг харгалзан магадлан итгэмжлэгдсэн спортын клубт үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлэх” гэж нэмсүгэй.” гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 24
Бүгд: 39

38.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хичээллэх” гэсний дараа “идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг харгалзан магадлан итгэмжлэгдсэн спортын клубт үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлэх” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчигт “**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ**” гэж нэмж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.19.“спортын барилга байгууламж” гэж олон улсын спортын холбооны дүрэм, стандартад нийцсэн олимп, тив, дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан орчин, хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий спортын зориулалтын барилга байгууламж, түүний дэд бүтцийг;” гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	18
Бүгд:	39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.33 дахь заалт нэмэх:

“4.1.33.спортын танхим” гэж иргэн, тамирчин биеийн тамир, спортоор хичээллэх, бэлтгэл хийх, спортын тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий байгууламж, түүний дэд бүтцийг.” гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	15
Бүгд:	39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Биеийн тамир, спортын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.8.спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 100 сая хүртэлх төгрөгийн, олон улсын спортын холбооны дүрэм, стандартад олимп, тив, дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан спортын зориулалтын барилга байгууламж, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад тухайн татварын жилд өгсөн 10 хүртэлх тэрбум төгрөгийн хандив, тусламж;” гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 13 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж ширээн дээрээ “МАЛЧДЫН ЗЭЭЛИЙГ ТЭГЛЭ!!!” гэсэн бичиг бүхий зурагт хуудсыг байрлуулсан байв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 21 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 19 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 28-ны
өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
15 цаг 04 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Хоёрдугаарт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Гуравдугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлж явуулна.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг үргэлжлүүлж явуулна.

Тавдугаарт, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Долоодугаарт, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Наймд, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Ес дэх. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Аравт, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Арван нэгд, Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж уг хэлэхээр Бөхчулууны Пүрэвдорж

гишүүн албан бичиг ирүүлсэн байна.
Пүрэвдорж гишүүн алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Анхны хэлэлцүүлгээр Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Эдийн засгийн байнгын хороо дууссан уу? Эдийн засгийн байнгын хороо дуусаагүй учраас хэлэлцэх асуудлын эхний 6 санал хураалт явуулах асуудлууд байна. Ингээд санал хураалт Байнгын хороо дуусахаар, явуулахаар хойшлуулаад эхний 6 асуудлыг санал хураалтад явуулахаар бас хойшлууллаа Дэгийн тухай хуулиар.

Одоо **Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг танилцуулна. Саранчимэг гишүүн алга байна. Энхболд дарга Гадаад бодлогын байнгын хорооны гишүүн мөн биз дээ тээ? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 5 сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 5 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг зүйл бүр тус бүрээр нь хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Энх-Амгалан нар төсөлтэй холбогдуулан үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нараас зарчмын зөрүүтэй 31 саналын томъёолол ирүүлсэн бөгөөд санал тус бүрээр хураалт явуулахад уг саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Түүнчлэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан, Энхболд

нараас ирүүлсэн зарчмын зөрүүтэй 4 саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулахад уг саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн зүйлийн 41.10-д заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт бүхий дүгнэлт болон Байнгын хорооны гишүүдийн дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн тусгай алба хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн/ найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Бригадын генерал Лхамсүрэнгийн Алтангэрэл Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, хурандаа Долгорсүрэнгийн Тэмүүлэн Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Хурцын Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Эрдэнэдашийн Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Чойжамцын Бат-Очир.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Энэ чинь 35 саналтай юм байна шүү дээ. 35 саналтай байна. Эдийн засгийн байнгын хороо яаж байна? Байнгын хороо, тэгээд бусад хурлууд? Хууль зүйн байнгын хорооны хурал яасан? Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо яасан? Байгаль орчны байнгын хороо дуусаагүй. Үгүй ээ, одоо дуусааж байна.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын санал хураалтыг хойшлууллаа.

30 минутын дараа дуудна. Та хэд орж ирээрэй. Ажлын хэсэгт баярлалаа.

Хууль зүйн байнгын хороо үүнийгээ дуусгаагүй.

15.13 цаг

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 69 дүгээр захирамжаар дээрх хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын

хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Учралаар ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Одонтуяа, Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 9, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдлаа.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын *d.parliament.mn* цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий 6 иргэнээс 6 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Тус Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 21, 24-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс хот, тосгоны удирдлагын зарчимд төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах зарчмыг тусгах, хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглах, шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж сэнд бокс орчинд туршиж, үр дүнг тооцоолох. Тосгоны удирдлага нь Тосгоны зөвлөл, Тосгоны захирагчаас бүрдэх бөгөөд Тосгоны зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх. Зөвлөлийн гишүүн

тосгоны захирагчийг оршин суугчдаас сонгох. Хот, тосгонд үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулах, хот нь эдийн засгийн тусгай бүстэй байж болох зохицуулалтыг тусгах зэрэг 38, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан орон нутгийн өмчийн болон удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.4 дэх хэсэгт заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын талаарх ИТХ-ын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлэхээр, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн удирдлагын талаарх Засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлэхээр тодорхой тусгах. Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байршилд тухайн хотын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатын тусламж, үйлчилгээ, спортын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварыг 5 жилийн хугацаанд чөлөөлж болох зохицуулалтыг нэмж тусгах зэрэг 46, нийт 84 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Мөн ажлын хэсгээс Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай

хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Ганболд, Чинзориг нар Өвөрхангай аймгийн Хархорин сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх талаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 10 хувийг орон нутгийн төсвийн орлогын бүрдэл хэсэгт нэмэх талаар 2 санал, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй.

Байнгын хороо, ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн

байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд байна уу?

Ажлын хэсгийн гишүүд байхгүй учраас хойшлууллаа. Ажлын хэсгийн гишүүд байхгүй учраас хойшлууллаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй санал, асуулт байхгүй учраас.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт, энэ уншиж байхад оруулахгүй яасан юм. Тэгээд ажлын хэсэг нь орж ирэхгүй. Танилцуулгыг нь уншаад байхад ажлын хэсэг нь байхгүй.

15.20 цаг

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Монгол ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5

дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 69 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Учралаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Батжаргал, Баттөмөр, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Мөнхүцэг, Одонтуяа, Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Ажлын хэсгийн дэмжсэн Шинэ Зуунмод хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэлд олон улсын банк санхүүгийн үйл ажиллагааг тусгаж, хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлж, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэрэгцээг хангах зорилгоор олон улсын санхүүгийн төв байгуулах, хотын бүтээн байгуулалтын хугацаанд хотын захирагчийг Нийслэлийн Засаг даргын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлөх зэрэг нийт 10 зарчмын зөрүүтэй санал, найруулгын 8 санал, хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар 6 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

15.24 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед асуулт асууж, үг хэлсэн гишүүн гараагүй болно.

Байнгын хороо ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Байхгүй байна.

Одоо хоёр Байнгын хороо хуралдаж байна. Тухайн Байнгын хороо хуралдаж дууссаны дараа санал хураалтыг явуулна. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 14.12-т заасны дагуу санал хураалтыг түр хойшлуулж байна.

Ажлын хэсгийнхэн түр явж байж болно. Санал хураалт хийх үед орж ирж болно. Одоо дараагийн асуудалдаа орно. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Гишүүд байраа эзлээрэй санал хураалтууд явагдана.

Энэ хооронд баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгуудыг сонсьё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцъё.

Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хяналт шалгалтын хууль явчихсан тийм ээ?

Дагалдан гарсан

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Адьяаа гишүүн сууж байгаарай. Дараа нь таны асуудлыг хэлэлцэнэ шүү.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Адьяаа гишүүн санал байгаа юм уу, үгүй юү? Байхгүй байгаа юм байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг сонсож дууслаа. Дараагийнхаа асуудалд орно.

15.32 цаг

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ш.Адъяаа: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Даваажанцаны Сарангэрэл, Жадамбын Бат-Эрдэнэ, Одонгийн Цогтгэрэл, миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрхийнхээ бүрэн эрхийн хүрээнд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсан.

Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг хэсэгт Монгол Улс тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн гэж заасан байгаа.

Энэ утгаар Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санааг дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний баяр наадмын тухай хууль 2022 оны 6 сарын 28-ны өдөр баталсан бөгөөд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 19.2-т Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно гэж заасан.

1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр, 7 дугаар сарын 13-ны өдөр уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж ирсэн бөгөөд жороо морины уралдааныг зохион байгуулах уяачид цол, чимэг олгох зохицуулалт тодорхойгүй байсан юм.

Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн холбогдох заалт, хэсэгт өөрчлөлт хоорондоо зөрчилдөхгүй бөгөөд жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид улс, аймаг, сумын цол, чимэг олгох эрх зүйн зохицуулалтыг хууль нэмж тусгасан болно.

Дээрх хуулийн зохицуулалт нь үндэсний морины уралдааны төрлийг нэмэгдүүлэх, эрт үеэс уламжилж ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн уяачдын наадмаар уламжлагдан зохион байгуулж ирсэн жороо морины уралдааныг хөгжүүлэх нь Монголын өв соёл, уламжлал, зан заншилыг түгээн дэлгэрүүлэхэд бодит хувь нэмэр оруулах болно.

Хуулийн төсөлд дээрх зохицуулалтыг оруулснаар дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна. Хуулийн төсөл батлагдсанаар эрт дээр үеэс уламжилж ирсэн жороо морины өв соёлыг ирээдүй хойч үедээ түгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Жороо морины уралдааныг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, уяачдын идэвх санаачилга, эрх зүйн байдал дээшилнэ. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болно. Үндэсний их баяр наадмаар жороо морины уяачийн эрх, үүрэг тодорхой болно. Жороо морины уяачийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, жороо морины уралдааныг зохион байгуулах эрх зүйн орчин бүрдэнэ. Хууль эрх зүйн хоорондын уялдаа холбоо сайжирна гэсэн ийм үзэл баримтлалын үүднээс энэ хуулийн төслийг өргөн барьсан болно.

Эрхэм Их Хурлын гишүүд та бүхэн хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хуулийн төсөл санаачлагч Адъяаа гишүүнд баярлалаа. Одоо төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал,

дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адъяа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хууль /шинэчилсэн/ найруулгыг Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан бөгөөд уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.19 дэх хэсэгт Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно гэж заасан байгаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.19 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулах жороо морины уралдаанд морин нь түрүүлсэн, айрагдсан уяачид улс, аймаг, сумын цол, чимгийг олгох нь эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, наадамчин олны жороо морио дээдлэн хүндлэх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд ач холбогдолтой гэж үзсэн байна.

Дээрх хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганболд жороо морины уралдаанд эрлийз морь уралдах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 72 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу?

Байхгүй. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Байнгын хороон дарга Энх-Амгалан асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа юм байна. Энэтэй холбоотойгоор жороо морины уралдаанд айрагдсан, түрүүлсэн ийм адууны эздэд бас цол, чимэг олгох ийм санаачилга гарч байгаа юм байна. Тэгэхээр 13-ны өдөр чинь бас нөгөө эрлийз морины уралдаан болдог. Тэгэхээр энийгээ дагаад бас эрлийз морь уралдуулсан хүнд бас цол, чимэг олгох барих, эрх зүйн байдлыг нь дээрдүүлэх гээд ийм юм дагаад ороод ирэх вий дээ. Энэ дээр ямар байр суурьтай байгаа юм. Одоо жороо морь нь ч яах вэ уламжлалт юм болж байна гэж бодох сон. Нөгөөдүүл нь бас яг адилхан морь уралдуулж байна шүү дээ. Энэ чинь эрлийз морь ч гэсэн морь шүү дээ гээд л. Ингээд л тэгээд л цол, чимэг авна гээд ингээд унах вий дээ. Энэ дээр ямар байр суурьтай байна вэ? Хууль санаачлагчдаас бас асууя.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагч Ширнэнбаньдийн Адьшаа хариулъя.

Ш.Адьшаа: Баярлалаа Энх-Амгалан гишүүндээ. Бас Эрлийз морины цол, чимгийн тухай асуулт асуулаа. Ер нь бол 2013 оноос эрлийз морь гэдэг энэ ойлголтыг, ийм уралдааныг Монголын төрийн баяр наадамд тодорхой хэсэг хүмүүсийн санаачилгаар оруулж ирсэн. Эрлийз морины уралдааныг уралдуулж улсын цол, чимэг олгож байсан. Энэ асуудал хэвээрээ л байгаа.

Тэгэхлээр энэ нэмж эрлийз моринд цол, чимэг олгох асуудал энд яригдахгүй. Зөвхөн жороо морины тухайд л энэ хуулийн үйлчлэл хэрэгжинэ. 13 оноос энийг Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулж 6 насны Монгол мориноос гадна эрлийз, дээд, дунд, бага гэсэн 3 насанд түрүүлж айрагдсан морьдод улсын цол, чимэг, аймгийн цол, чимэг, сумын цол, чимэг олгож байгаа. Энд хуулийн ямар нэгэн өөрчлөлт орох асуудал байхгүй гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлнэ.

5 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдийн Адьшаа төрсөн байна.

Танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд, гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Хуулийн төсөл хэлэлцүүлэх үедээ бас мэндчилгээгээ дэвшүүллээ. Адьшаа гишүүн бол Шуургачийн Ширнэнбаньд, Чавхандаан Үржсин-Орлох гэсэн хүмүүсийн, 6 хүүхэдтэй айлын ууган хүүхэд нь болон мэндэлсэн байна. Адьшаа

гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж, сайн сайхныг хүсье.

Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу?

Үг хэлэх гишүүн алга байна.

Санал хураалтууд явагдана. Гишүүд танхимд байраа эзлээрэй. Гишүүд танхимд байраа эзлээрэй, удахгүй бас санал хураалтууд явагдана. Байнгын хороодын хурлууд дуусаж байгаа байх тийм үү? Хоёр Байнгын хороо хуралдаад байгаа арай дуусаагүй байна уу?

Байнгын хороодын хурал дуусахаар санал хураалтуудыг явуулна. Энэ хооронд эцсийн найруулгыг танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэд иргэдийн санал авах журмыг 1 дүгээр, нэгжийн өөрчлөлтийн төслийн үндсэн мэдээллийг 2 дугаар, саналын хуудсыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай гэсэн байна.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Байнгын хорооны хурал дуусахаар санал хураалтыг явуулна. Учрал сайд аа хүрээд ир ээ.

Адъяаа гишүүний санаачилсан хуулийн санал хураалтыг түр хойшлууллаа. Дараагийнхаа асуудлаа явъя.

15.51 цаг

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэг, бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ганибал, Ганхуяг, Ундрэм, Энхтүвшин

нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс асуулт асууж, санал хэлээгүй болно.

Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдах улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгах, төр, хувийн хэвшлийн түншил болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг жигд зохион байгуулах, дэд бүтцийн чиглэлээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг төсөлд нэмж тусгах зарчмын зөрүүтэй саналын томъёолууд болон тогтоолын төслийн хавсралтад тусгагдсан бусад төсөл, арга хэмжээний нэр томъёог жигдлэх, тоон үзүүлэлтүүдийн хувьд хувь, хэмжээг өөрчлөх саналууд бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг ашиглаж үнэлэх, үр дүнг хангахад чиглэх гэсэн зарчмын зөрүүтэй

санал гаргасанг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг оруулаарай. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу?

Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хоршооны асуудлаар би малчдад бас тодорхой хэмжээний анхааруулгыг хэлсэн. Өөрөөр хэлбэл, хоршоонд зээл авахдаа бас болгоомжтой байгаарай, янз янзын эрсдэл гарга уу за гэсэн, анхааруулсан. Анхааруулсан чинь одоо зарим нэгэн хүмүүс тодорхой хэмжээгээр.../үг тасрав./

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбогдуулж үг хэлнэ шүү.

Б.Пүрэвдорж: Тийм ээ тийм. Би сүүлд нь хэлнэ. Би хоршооны хуулиар бас тодорхой хэмжээгээр хүмүүст анхааруулж энэ болгоомжтой зээл аваарай гэдэг зүйлийг хэлсэн. Энэ дээр бас зарим хүмүүс анхааруулсны төлөө уучлал гуй гэж байх шиг байна.

Тэгэхээр ер нь би энэ асуудал дээр зээлээ авдагараа авцгаа, тэгээд

хоршоонд хамтарч байгаа тэр хүмүүс дээрээ л жоохон болгоомжтой байгаарай л гэж би анхааруулаад байгаа юм. Ер нь бол мэдээж янз янзын эрсдэл гарч магадгүй. Тэгэхэд тэр тохиолдолд зөв ажилласан хүмүүс нь төлөх ийм нөхцөл байдал бий болох вий л гэдгийг би хэлээд байгаа юм.

Ер нь энэ хоршоондоо зээл авчхаад малчид хамгийн эхний ээлжид.../үг тасрав./

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүнээ өнөөдөр “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэж байна. Энэ асуудалтай холбоогүй асуудал байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор одоо санал хураана. Одоо ажлын хэсгийг танилцуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн, Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүйн Мягмар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтын Баярбат, Боловсрол, шинжлэх ухааны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал. Батжаргал хаана явна?

Дуудаарай. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Чимэдцэрэнгийн Цэвэгдорж.

Энэ ажлын хэсгийнхэн чинь хаана байгаа юм бэ? Ажлын хэсгийн. Ажлын хэсэг нь алга байна. Уг асуудлыг түр хойшлууллаа.

Саяны асуудал ажлын хэсэг байхгүй байсан учраас түр хойшлуулсан. Дараагийнхаа асуудалд орж байя.

15.57 цаг

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг

арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар хуулийн төслийн хэрэгжих хугацаатай холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор

хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цогтбаатар даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу?

Байхгүй байна. Айн? Энэ болохоороо Хууль зүйн байнгын хорооны асуудал байгаа. Алга байна. Энэ Пүүжээ нээрээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтууд явагдана.

Байнгын хороодын хурал дуусахаар санал хураалтуудыг нэгтгэж явуулах гээд бас хүлээгээд байгаа шүү. Гишүүд хурлаа дуусгаад яаралтай орж ирээрэй. Дараагийнхаа асуудалд оръё.

16.05 цаг

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хур Хурал 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ундрам гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, Хууль, эрх зүйн газрын захирал Дунхүүгийн Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Найманжсингийн Ариунбат нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу?

Алга байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явагдана. Санал хураалтыг түр хойшлууллаа.

16.08 цаг

Гишүүд танхимдаа орж ирье. Боловсролын байнгын хороо хуралдаж дууссан байна. Гишүүд танхимдаа орж ирээд санал хураалтуудыг явуулъя. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт явагдана шүү.

Боловсролын байнгын хороо хуралдаж дууссан байна. Одоо санал хураалтуудаа явуулна. Чуулганыхаа нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлъя.

Гишүүд байр эзлээрэй. Гишүүд байраа эзэлье. Өнөөдөр бас гурван Байнгын хороо хуралдсан. Гурван Байнгын хороо хуралдаад сая дууслаа. Одоо нэгдсэн чуулганы хуралдааныг үргэлжлүүлээд явуулна.

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Бүртгэлийн санал хураалт явуулъя.

Гайгүй байх. Суудлаа эзэлье. Адьшаа гишүүн суудалдаа сууя. Пүрэвдорж гишүүн санал хураалтдаа

орье. Саналын томъёоллыг уншиж танилцуулна. Оюунчимэг гишүүн, Аубакир гишүүн эд нар суудлаа эзлээрэй. Саранчимэг гишүүн бас суудлаа эзэл. Санал хураалт явуулна.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Байнгын хороо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

Нямаагийн Энхболд даргаа санал хураалт, горимын саналаа гаргая.

Н.Энхболд: Сая минийх ажилласангүй. Би дарсан юм. Дахиад саналаа хураагаад, хүчингүй болгоод дахиад санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ. Уг санал хураалтыг хүчингүйд тооцсон.

Үндсэн санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026 оны 2026-2027 оны төсвийн төсөөллийн

тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийнхаа санал хураалтад орёе. Зарчмын зөрүүтэй санал байгаа билүү? Дараагийнхаа асуудлаар Аж ахуйн нэгжсийн юун дээр тийм ээ? Айн? Дараагийнхаа асуудал, дараагийн санал хураалтыг түрүүн түр хойшлуулчихсан байгаа юм. Одоо саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа санал хураалтыг явуулъя.

17.07 цаг

Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж байна.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна. Үүгээр санал хураалгачихъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт.

59.9 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Дараагийн асуудалд орёе.

17.09 цаг

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай”, “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд.

60 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудалд оръё.

17.10 цаг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Асуулт, хариулт явагдаж дууссан. Санал хураалт байгаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудлаа явъя.

17.11 цаг

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууссан.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтаа явуулъя.

Хөгжлийн төлөвлөгөө, энэ хуулийн хугацаатай зүйл байгаа. Ажлын хэсгийг оруулаарай. Санал хураалтуудыг явуулъя.

“Монгол Улсын 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн дараах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.3 дахь заалтын “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийн ААНОАТ-ыг 5 хувь болгоно.” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Ганхуяг. Энхтүвшин. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.16 дах дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Ховдын Дөргөн”- “Завханы Загастайн даваа”-ны урд яруугийн уулзвар чиглэлийн 375 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Ховд, Завхан) гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “3,187.50” юм уу тээ? 50 гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 2000 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “17,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.19 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, мөн адил юм уу тийм ээ? Тийм байна. Адилхан юм байна. Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 200 км авто зам барих (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, 200 км гэдэг нь зөв.

Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд 100 сая юм уу энэ? 100 тэрбум юм уу 100 сая юм уу? “100,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27.5 хувиар дэмжигдсэнгүй. 11 гишүүн дэмжсэн байна.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.17 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Алтай-Бургастай боомт чиглэлийн 253 км хатуу

хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “101,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27.5 хувиар дэмжигдсэнгүй.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Хожуулын голын гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “7,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

15 гишүүн буюу 37.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.21 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Идэр голын 96 у/м төмөрбетон гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “8,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

14 гишүүн буюу 35 хувиар дэмжигдсэнгүй.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.22 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хүнгүйн голын, энэ сая дэмжигдээгүй уначихлаа тийм ээ? Одоо 9.

8 дугаар санал хураалтыг түрүүн уншаад танилцуулчихсан.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.22 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “5,040.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал хураалт.

20 гишүүний 48.8 хувиар дэмжигдсэнгүй.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Байдрагийн усан цахилгаан станц барих (Баянхонгор аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “30” гэж, Санхүүжилтэд “54,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй.

55 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Авто замын засвар арчлалтын ажилд шаардлагатай асфальтбетон завод, тоног төхөөрөмж худалдаж авах /Улсын хэмжээнд/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Тоног,

төхөөрөмж” гэж, Хэмжих нэгжид “тоо” гэж, Суурь түвшинд “4” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “4,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал хураалт гишүүд ээ. Яах вэ энэ авто замын засварын арчилтын асуудал дээр л юм байна шүү дээ. Тоног төхөөрөмж худалдаж авах гэж байгаа юм байна. Энэ санал нь бас уначихлаа даа. Энэ тэгээд л уг нь чухал л санал байх шиг байх юм.

18 буюу 45 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд та нар ажлын хэсэг, энэ дэд ажлын хэсгийнхэн тэгээд оруулж ирсэн зүйлүүд чинь бүгд дэмжигдэхгүй байна шүү. Энэ асуудалдаа анхаараарай. Дараагийн асуудалдаа орёе.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газрын барилга барих” Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ. Саналаа өгөөрэй.

15 гишүүн буюу 37.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.6 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Үндэсний хиймэл дагуулын дэд бүтцийг байгуулах” гэснийг “Монгол Улсын Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл

хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Төслийн хэрэгжилт” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэснийг “75” гэж, Санхүүжилтэд “1,600.00” /Нэг тэрбум зургаан зуун сая/ гэснийг “568,716.33” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ. Ирц бол хангалттай байгаа. Тэгээд гишүүд өөрсдийнхөө итгэл үнэмшилээр саналуудаа өгч байна.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын. 13 тийм ээ?

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний нөөцийн аудитын ажлыг сайжруулах, ёс зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Төрийн албаны зөвлөл” гэж тус тус нэмэх гэсэн байна.

Энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны асуудал юм байна. Санал хураалт. Ёс зүйн хууль дагаад явж байгаа юм байна. Сандаг-Очир гишүүн горимын санал гаргах юм байна. Гаргая.

Ц.Сандаг-Очир: Нэгт, саяын санал хураалтаас хоцорчихлоо. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөд дахин санал хураалт өгөөч нэгт.

Хоёрт, бас санал хэлэх гэсэн юм. Эртээд хэлэлцэх эсэх дээр 1 санал

оруулсан. Тэгээд Хөгжлийн сайд оруулах нь зүйтэй гээд ингээд ярилцсан. Тэгээд энэ удаагийн зарчмын зөрүүтэй саналд огт ороогүй байна. Эдийн засаг, хөгжлийн яамныхан анхаараач дараагийн хэлэлцүүлэг дээр. Багануурын дулааны станцын өргөтгөлийн асуудал гэж ингэж ярьсан. Тэр нь зүйтэй. Одоо яригдаж байгаа энэ Хятадын цахилгаан станц нь ер нь тодорхойгүй, ер нь бараг худлаа тал руугаа орсон.

Тийм учраас одоогийн байгаа станцын өргөтгөх асуудлыг ярьсан. Эртээд тэгээд дэмжигдээд Эдийн засаг, хөгжлийн сайд оруулаад ирье гэж өөрөө бүүр ярьсан. Тэгтэл энд одоо юу ч орж ирээгүй байна шүү. Энэ дээр анхаарч өгөөрэй.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний горимын саналаар санал хураая. Сандаг-Очир гишүүний саяын хэлсэн асуудлуудыг бас анхаарах нь зүйтэй. Энэ анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах боломж байгаа юу гэдэг асуудлаа ажлын хэсэг дээр яриарай. Санал хураалт.

Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

55 хувь санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцогдлоо. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт, үндсэн санал хураалт явагдаж байна шүү.

55 хувиар санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх” гэснийг “Эмээлт Эко Аж Үйлдвэрийн паркийн дулаан болон цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Цахилгаан хангамжийн барилгын ажлын гүйцэтгэл” гэснийг “Ажлын

гүйцэтгэл” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэснийг “25” гэж, Санхүүжилтэд “14,800.00” гэснийг “112,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал дэмжигдсэн.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “85,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвилийн түншилэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

40 хувиар санал дэмжигдсэнгүй.

16 гишүүн буюу 40 хувиар дэмжсэн байна. Тэгээд санал дэмжигдсэнгүй.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Туул усан цогцолбор барих төслийг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “426,740.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвилийн түншилэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүд дэмжээд уул нь саналаа өгвөл зүгээр байна. Гэхдээ энэ хотын гишүүд чинь хаана байна? Тэр хотын асуудлаа л баахан хэлэлцээд байдаг хотын гишүүд чинь алга байна шүү дээ. Тийм байна. СБД-ийнхэн байна, ЧД-ийнхэн байна, СХД-ээс Жаргалмаа, Батшугар нар байна. Сүхбаатар, Чингэлтэйгийнхэн бүрэн байна. БЗД-ээс Энхбаяр сайд байна. Ингээд хотын гишүүд алга байна. Хотын асуудлууд чинь энэ чухал чухал асуудлууд чинь ингээд унаад байна шүү дээ.

17 гишүүн буюу 42.5 хувиар санал дэмжигдсэнгүй. Ирц хангалттай байгаа. Гишүүд бол дэмжих зүйлээ бүрэн дэмжээд байна шүү дээ. Тэгээд тодорхой хэмжээнд гишүүд өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд л саналаа өгч байгаа.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Гадаадын тусламж, Улсын төсөв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

19 гишүүн буюу 47.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд ““Сэргээгдэх эрчим хүч бүхий дулаан автобусны буудал барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “9,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал хураалт.

17 гишүүн буюу 42.5 хувь нь дэмжсэн байна. Санал дэмжигдсэнгүй. Энэ уул нь чухал санал байх юм даа.

Гишүүд дэмжихгүй байна даа.
20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын.

19 тийм ээ? Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Гэр хорооллын далан дагуух авто зам төсөл хэрэгжүүлэх /Баянгол дүүргийн 21, 9, 10, 22 дүгээр хороо/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

15 гишүүн буюу 37.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй ээ.

Уул нь асуудлуудаа өөрсдөө оруулсан хүмүүс нь хамгаалах хэрэгтэй дээ. Үндэслэлээ хэлэх.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.3.3.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Баянгол дүүргийн Цагдаагийн газрын барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “13,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж тус тус нэмэх.

Энэ Энхбаяр сайд Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцах ийм санал хураалт юм байна. Гишүүд дэмжихээрэй. БГД дээр. Санал хураалт. БГД-т Цагдаагийн газрын барилга л барья гэж байгаа юм байна шүү дээ. Ийм санал байна. Дэмжээд явчихъя.

Сарангэрэл гишүүн гаргах юм уу?
Хэн гаргах юм?

17 гишүүн буюу 42.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй. Улсынхаа төсөв ярих үедээ ярина биз тийм ээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах” гэснийг “Хавдар судлалын Үндэсний төв-II-ийн дэд бүтэц барилгын ажлыг эхлүүлэх” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэснийг “110,000.00” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ гишүүд анхааралтай байж байгаарай, дэмжээд орхиорой. Хавдар судлалын II дахь төвийг барья гэж байгаа юм байна шүү дээ. Энэ их чухал санал байна. Гишүүд анхааралтай байгаарай. Энэ саналыг дэмжье. Дэмжье гэсэн томъёолоор санал хураалт явуулъя.

Хавдар судлалын Үндэсний төв II дахь төвийг барьж байгуулах гэсэн асуудал 57.5 хувиар дэмжигдлээ. Дараагийнхаа асуудлыг харъя.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.7 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

11 гишүүн буюу 27.5 хувиар хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын төсөл арга хэмжээнд Яаралтай тусламжийн төв барих 23-ыг уу? 23-ыг танилцуулаад орхиё.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвшлийн түншилэл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Саяынхыг дэмжчихгүй байсан юм уу? Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргачихъя.

Ц.Мөнхцэцэг: Сая миний санал хураалтын төхөөрөмж гацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ саналаа өгөөрэй.

53.8 хувиар санал дэмжигдлээ.
24.Тогтоолд.

Уг санал хураалтыг хүчингүйд тооцсон. Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалтаа явуулъя. 23 дахь санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Яаралтай тусламжийн төв барих (Орхон аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “5,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт дэмжье. Дэмжье, дэмжье бүгдээрээ.

Орхон аймагт яаралтай тусламжийн төв барих санал хураалт

дэмжигдсэн байна. 56.4 хувиар дэмжигдлээ.

Саяынх дээр харин 2 аймаг нэмж бичих байсныг юу яасан байна шүү.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.8 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Өрх, гэр эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Булган аймаг)” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж, мөн заалтын Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Хөвсгөл аймаг)” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дэмжье гишүүд ээ.

Сарангэрэл гишүүн горимын санал гаргая.

Д.Сарангэрэл: Даргаа саяын санал хураалт дээр би саналаа бас арай хоцроод өгчихлөө. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүний төхөөрөмж ажиллаагүй юм байна. Ингээд уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Санал хураалтыг хүчингүйд тооцъё.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Уг санал хураалтыг хүчингүйд тооцсон. Одоо үндсэн санал хураалтаа явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүдэд баярлалаа. Дараагийн санал хураалтыг явуулъя.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.19 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Мөрөн-Улиастай” чиглэлийн хатуу хучилттай авто зам төсөл барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “10” гэж, Санхүүжилтэд “43,590.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр, хувийн хэвшлийн түншилэл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. Дэмжье бүгдээрээ. Тийм байна. Төр, хувийн хэвшилтэй хамт гэж байгаа гэсэн л юм байна.

18 гишүүн буюу 46.2 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.3 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэнд хуульчдыг мэргэшүүлэх”, гэж, Шалгуур үзүүлэлтэд “Мэргэшүүлэх хуульчдын тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “1,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ХЗДХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүд дэмжээд саналаа өгчихье. Энэ хувийн эрх зүйн чиглэлээр мэргэжлүүдээ бэлтгэе гэж байна шүү дээ. Хамгийн их хоцрогдсон. Санал хураалт, чухал санал хураалт шүү.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүд суугаарай. Одоо хоёрхон санал байна. Хоёрхон санал хураалт байна.

28.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх

4/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг ашиглаж үр дүнг хангахад чиглэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг гэсэн байна. Санал хураалт. Гишүүдээ санал хураалт.

19 гишүүн буюу 48.7 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

Найруулгын санал байна.

Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд иилжүүлээ. Дараагийнхаа асуудалд оръё.

17.52цаг

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Асуулт, хариулт явагдаад дууссан.

Байнгын хороо Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ.

Жаргалмаа гишүүн горимын санал гаргая. Жаргалмаа гишүүний микрофоныг өгөөрэй.

Б.Жаргалмаа: Уг нь даргаа кнопоо дарсан боловч дарагдаагүй байна. Тэгээд энэ саналыг хүчингүйд тооцоод, дахин санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаагийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя гишүүд ээ.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон. Сая хүчингүйд тооцсон санал хураалт дэмжигдсэн. Одоо үндсэн саналын томъёоллын уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд илжжүүлээ. Дараагийнхаа асуудал оръё.

17.55 цаг

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гишүүд асуулт, хариулт авч дууссан байгаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 35 санал байгаа. Санал хураалтыг явуулъя. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт явуулъя.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, шинэчилсэн найруулга, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын танилцуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналууд байна. Санал хураалтыг явуулна.

1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход оршино.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн гарчиг,

6.1 дэх хэсэг, 6.1.5, 6.2.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хүн”, “хүний”, “хүнийг” гэснийг тухай бүрд “иргэн”, “иргэний”, “иргэнийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан, Энхболд. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг тус тус хасаж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахаас сэргийлэх” гэснийг “үндсэн хуульд байгууллын аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “айлчилж байгаа” гэсний дараа “болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан, Энхболд. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалтыг доор дурдсанаар 6.2.6, 6.2.7 болгон өөрчлөн найруулах:

“6.2.6.энэ хуулийн 6.1.6-д заасан зочин айлчлах болон дамжин өнгөрөх хугацаанд;

6.2.7.энэ хуулийн 6.1.7-д заасан зочин айлчлах хугацаанд болон хүсэлт гаргавал Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хугацаанд.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

18 цаг болсон байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлыг дуусаагүй байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Төрийн тусгай

хамгаалалтын байгууллага” гэснийг хасаж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 7.2-т” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “барилга байгууламж” гэснийг “барилга, бусад зүйл” гэж, мөн хэсгийн болон 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “маршрутын” гэснийг “чиглэлийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь хэсгийн “маршрут” гэснийг “чиглэл” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж өөрчилж, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Олон улсын дээд хэмжээний уулзалт, хурлыг төрийн тусгай хамгаалалтад авахад шаардагдах зардлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.5.Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх бусад зүйлийн жагсаалтыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн Засгийн газар батална.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан, Нямаагийн Энхболд. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

51.3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “байж болно” гэснийг “байна” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “бусад хүн” гэснийг “бусад этгээд” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хүн” гэснийг “аливаа этгээд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь хэсгийг нэгтгэж, 13.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Хамгаалалтын дэглэмээр тодорхой эд зүйл нэвтрүүлэхийг хориглох, зорчих хөдөлгөөн болон тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, түр зогсоох, хяналтын дэг журам тогтоох зэрэг бусад үйл ажиллагааг явуулж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ. 9. 9-ийг сая хураасан тийм ээ?

10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг болон 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг нэгтгэж, 14.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасан урьдчилан сэргийлэх, хамгаалалтын техникийн, орчны болон эрүүл ахуйн үзлэг хийх журам, зааврыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “олон улсын дээд хэмжээний” гэсний дараа “уулзалт,” гэж нэмж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хамгаалалт найдвартай байхад чиглэсэн” гэснийг “хамгаалалтын бусад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “байгууламж,” “найдартай” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн

Энх-Амгалан, Энхболд. Ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “барилга байгууламжийг” гэснийг “барилгыг” гэж, 17.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “барилга байгууламжийн” гэснийг “барилга, бусад зүйлийн” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ХҮЛЭЭХ ҮҮРЭГ” гэснийг “ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ” гэж, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлийн гарчгийн “үүрэг” гэснийг “чиг үүрэг” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх” гэснийг “хэрэгжүүлэх чиг үүрэг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Төрийн тусгай хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд төрийн бусад байгууллага энэ хууль болон холбогдох хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлэн оролцоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувийн санал дэмжигдлээ.

15.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “эрүүгийн” гэсний дараа “болон хэв журмын талаар” гэж нэмж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчин болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналт тавьж, лабораторийн шинжилгээ хийнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51.3 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “ашигийн төлөө бус” гэснийг “төрийн бус” гэж, 24.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, ашигийн төлөө бус байгууллага” гэснийг “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал зөвлөгөөг тусгаж ажиллана” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын байгууллагад урьдчилан мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал, зөвлөгөөг тусгаж хамтран ажиллана” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “үзүүлж хамтран ажиллана” гэснийг “үзүүлэх үүрэг хүлээнэ” гэж өөрчилж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “хуульд заасан хүрээнд зохион байгуулж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 27 дугаар зүйлийг 28 дугаар зүйлтэй нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг

27.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1.төрийн тусгай хамгаалалтыг зохиох, хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах;

27.1.2.төрийн тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийг хамгаалах;

Тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийг хамгаалах та нар энэ нэр томъёон дээрээ хараарай.

27.1.3.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;

27.1.4.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

27.1.5.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиглүүлэх;

27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, энэ хуульд заасан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

27.1.7.энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан болон иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;

27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;

27.1.9.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

27.1.10.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчид Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

27.1.11.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлд лабораторийн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;

27.1.12.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсэд радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;

27.1.13.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан хамтран ажиллах;

27.1.14.төрийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийн

санд нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;

27.1.15.төрийн тусгай хамгаалалтыг далд хэлбэрээр хэрэгжүүлэхдээ өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;

27.1.16.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;

27.1.17.гадаад улсын төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

27.1.18.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;

27.1.19.энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийг өргөө, зориулалтын орон сууц, үйлчлэх бүрэлдэхүүн, эдийн болон хүнсний бүтээгдэхүүнээр хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, өргөө, зориулалтын орон сууцны ашиглалтын техникийн бэлэн байдлыг хариуцах;

27.1.20.хамгаалуулагчид зориулалтын тээврийн хэрэгсэл, тусгай холбоогоор үйлчлэх;

27.1.21.төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд холбогдох байгууллагатай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

27.1.22.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм сахиулах, халдлага, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

27.1.23.чиг үүргийнхээ хүрээнд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

27.1.24.үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг

ашиглах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

27.1.25.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах;

27.1.26.байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

27.1.27.хуульд заасан бусад. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг түр түдгэлзүүлээ. Байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан үг хэлье. Нэлээн өргөн хүрээтэй л эрхтэй болж байгаа юм байна. Микрофоныг нь өгөөрэй Энх-Амгалан даргын.

Б.Энх-Амгалан: Энэ төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийн хэсэг дээр байгаа 27.1.8, 27.1.12, 27.1.15, 27.1.24 дээр заасан заалтуудыг та бүхэн маань нэг мөр ингэж ойлгоорой. Би яагаад гэвэл протоколд үлдээх үүднээс хэлж байгаа юм. Энэ гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6.3, 8.1-д заасан зүйлдэнэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байгууллага албан тушаалтан, хувь хүн гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл ашиглах, аливаа техник хэрэгслийг гүйцэтгэх ажлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно гээд заачихсан байгаа.

Тэгэхээр энэ маань тэр чиглэл рүү ойртоод байгаа учраас энийг гүйцэтгэх ажлын тусгай техник, хэрэгсэл биш шүү гэдгийгээ энийг тодорхойлох хэрэгтэй.

Хоёрдугаарт нь гүйцэтгэх ажлын 6.3-д хуулиар ийм эрх олгогдоогүй байгууллага гүйцэтгэх ажил явуулж

болохгүй гэж байгаа юм. Тэгэхээр төрийн тусгай хамгаалалтын байгууллага хуулиар энэ гүйцэтгэх ажил явуулах ийм эрх олгогдоогүй учраас энийг энэ дээрээ ингэж ойлгож цааш нь авч хэрэглээрэй гэдэг юм хэлэхгүй бол хуулийн зөрчил гарч магадгүй учраас би энэ дээр протоколд үлдээж байгаа шүү. Анхаараарай. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Санал хураалттай холбогдуулан Энх-Амгалан гишүүн үг хэллээ.

Саналын томъёоллын уншиж танилцуулсан. Санал хураалт.

59 хувийн санал дэмжигдлээ.

20.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээд” гэснийг “бусад этгээд” гэж өөрчилж, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 32.1.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “биелэлтийг хангуулах” гэснийг “мөрдүүлэх” гэж, 32.1.10 дахь заалтын “мэдлэг чадварыг” гэснийг “мэдлэг, ур чадварыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 32.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.7.төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг дотоод, гадаадад төлөөлөх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ саналаа өгөөрэй.

59 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Энэ хуульд заасан” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн” гэж, “албан хаагч байна” гэснийг “албан хаагч мөн” гэж тус тус

өөрчилж, мөн зүйлийн 33.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.4.Шадар хамгаалалтын ажилтан нь төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсгийн “алба хаагч нь байгууллагаас олгосон албаны үнэмлэхтэй байх ба” гэснийг хасаж, 35.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.8.Аливаа этгээд төрийн тусгай хамгаалалтын албаны дүрэмт хувцас, үнэмлэхийг хэрэглэхийг хориглоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 33.2-т” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “энэ хуулийн 11.4-т заасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.3.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн мэдлэг, ур чадвар, туршилага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын “холбоотой” гэсний дараа “хууль ёсны” гэж, мөн зүйлийн 37.1.6 дахь заалтын “эд зүйлд” гэсний өмнө “бие болон” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.1 болон 38.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.1.өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтын “явахгүй” гэсний, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “тавихгүй” гэсний дараа “байх” гэж тус тус нэмж, 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтыг 38.1.7 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.7.өөрийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжил, мэргэшил, албаны бэлтгэлийн түвшинг хадгалах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувийн саналаар.

29.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “холбогдон” гэснийг хасаж, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалтын “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг хасаж, 42 дугаар зүйлийн

42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, буцах замд явах болон энхийг дэмжих ажиллагаанд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувийн санал дэмжигдлээ.

31.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэмт халдлагын улмаас” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дараах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцье.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Төрийн ордон нь төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7.7 дахь хэсгийг нэмэх:

“7.7.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж энэ хуулийн 3.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй

байдлыг хариуцна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.8 дахь хэсгийн “дарга болон дотоодын цэргийн командлагчийн” гэснийг “даргын” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйлчилгээ явуулах болон засвар” гэсний өмнө “ордонд” гэж, “үйлчилгээний тусгай” гэсний өмнө “ордны” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийнхаа асуудалд орёё.

18.28 цаг

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг түрүүн танилцуулсан байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 8 санал байгаа. Санал хураалтыг явуулъя.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “Сонгуулийн сурталчилгааны” гэсний өмнө “Нэгээс илүү сувагтай радио, телевиз нь” гэж нэмж, 37 дахь хэсгийн “нэр дэвшигч оролцсон” гэсний

дараах “, эсхүл” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар.

55 хувиар санал дэмжигдлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ горимын санал гаргая.

Б.Бат-Эрдэнэ: Миний санал дарагдсангүй. Яагаад өгөөч Мөнхбаатар даргаа дахиад горимын саналаар хүчингүй болгоод дахиад санал хураагаад.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

55 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцогдсон.

Одоо үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх. Сая хураачихсан шүү дээ. Тэгсэн.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд

хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

18.37 цаг

Тогтохсүрэн гишүүн горимын санал хураая.

Д.Тогтохсүрэн: Өнөөдөр дарга хотын хоёр хуультай холбоотойгоор сая Учрал сайд бид нар ярилцлаа. Бас ирц бага байгаа учраас 4 дэх өдрийн чуулганаар хэлэлцүүлье гэж байна. Тэгэхээр өнөөдөр цаг жаахан сунгаад энэ Засгийн газраас өргөн барьсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдуулан өргөн барьсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороо хуралдаад анхны хэлэлцүүлэг хийчихсэн юм байна.

Тийм учраас энэ асуудлыг хэлэлцэж дуусгаад өнөөдрийн чуулганаар завсарлалчигвал яасан юм бэ гэдэг ийм горимын санал гаргаж байна. Таныг горимын саналаар санал хураалт хурааж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг санал хураалт явуулъя.

Тогтохсүрэн даргын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор.

Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан дараагийнхаа асуудлыг хэлэлцье.

18.37 цаг

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэг бэлдүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 2 дугаар сарын 2 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгээр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Адъяасүрэн, Аубакир, Ганхуяг, Жаргалмаа, Чинбүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсан бөгөөд ажлын хэсгээс хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

Тус Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэн, дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1.Допингийн эсрэг үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэж холбогдох байгууллагуудын чиг үүрэг, ажлын уялдаа холбоо, хяналтыг боловсронгуй болгох зорилгоор допингийн эсрэг үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг тусгай бүлэг болгон оруулав.

2.Олон улсын олимпын ...-ын дэлхийн допингийн эсрэг дүрмийг үндэслэн допингтой холбоотой маргааныг олон улсын спортын арбитрын шүүхээр шийдвэрлэж байхаар зохицуулав.

3.Тухайн нутаг дэвсгэрийн онцлог төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн биеийн тамир спортын байгууллагын биеийн тамир, спортын ажилтан, арга зүйч, дасгалжуулагчид 5 жил тутам 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгохоор тусгав.

4.Олимп, тив дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин эрүүгийн хариуцлага хүлээсэн бол сар бүрийн мөнгөн урамшууллыг ял шийтгэл эдлэх хугацаанд нь олгохыг зогсоохоор тусгав.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахад Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэгт баярлалаа. Санал хураалтыг явуулъя.

Биеийн тамир, спортын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “сэтгэл оюуны болон” гэснийг, мөн заалтын “үүний үр дүнд оюун ухааны болон” гэснийг, 4.1.3 дахь заалтын “мэргээжлийн” гэснийг, мөн заалтын “биеийн тамир баги, дасгалжуулагч, арга зүйчийн мэргээжлээр” гэснийг, 4.1.16, 4.1.31 дэх заалтын “дунд зохион байгуулах” гэснийг, 4.1.17 дахь заалтын “дүрэм, журмыг” гэснийг, 4.1.22 дахь заалтын “үндсэн дээр мөнгөн урамшуулал авахгүйгээр” гэснийг, 4.1.30 дахь заалтын “зэрэг үндэсний уламжлалт спортыг” гэснийг тус тус хасаж, мөн

зүйлийн 4.1.11, 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11. “идэвхтэй хөдөлгөөн” гэж эрүүл мэнд, бие бялдрыг дэмжихэд чиглэсэн хүний булчингийн үйл ажиллагааг 30 минутын хугацаанд идэвхтэй ажиллуулах дасгал хөдөлгөөнийг;

4.1.18. “спорт” гэж биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэн, тэмцээн, наадамд тусгай журмын дагуу бэлтгэж оролцох үйл ажиллагааг;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Адъяасүрэн, Т.Аубакир, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

Ажлын хэсгийг оруулаарай.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “дэмжих замаар нийгэмд эерэг хандлагыг дэлгэрүүлэх үйлсэд” гэснийг “дэмжихэд” гэж өөрчилж, мөн заалтын “хичээллэх,” гэсний дараа “спортын” гэж, 5.1.6 дахь заалтын “хүүхдийг” гэсний өмнө “эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Бат-Эрдэнэ гишүүн, төхөөрөмж ажиллаагүй юм байна. Горимын санал гаргачих.

Б.Бат-Эрдэнэ: Уучлаарай миний төхөөрөмж ажилласангүй. Би сая төхөөрөмжөө сольчихлоо, солиод картаа бүрдүүлчихсэн. Тийм учраас горимын санал гаргаж байна. Саяын саналыг хүчингүй болгох санал.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан горимын санал гаргая.

Б.Жавхлан: Энэ жоохон будилчихлаа. Тийм, дахиж санал, энэ саяын санал санал хураалтыг хүчингүй болгож өгөөд, дахиж хураалгаж өгөөч. Би өөрөө будилчихлаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Суугаарай.

57.5 хувиар Жавхлан гишүүний гаргасан санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцогдлоо.

Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хүндлэл” гэснийг, мөн заалтын “мөн чанарыг эрхэмлэх зэрэг” гэснийг, 7.1.6 дахь заалтын “иргэн болон өөр хоорондоо хүндэтгэлтэй, эелдэг харьцаж,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 7.1-д заасан этгээд ёс зүйн зөрчил гаргасан бол Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ёс зүйн шийтгэл хүлээх хугацаанд мөнгөн шагнал, урамшуулал олгохыг түр түтгэлзүүлэх шийдвэрийг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн

хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Эрдэнийн Тэмүүжин. Өөр хэн ирсэн байна? Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Осорын Баттулга, Биеийн тамир, спортын салбарын судлаач Халимханы Бакытжан, Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны ажлын албаны мэргэжилтэн Баярсайханы Өлзийбаяр нар оролцож байна.

Тэр хэн Жаргалсайхан ирсэн юм уу айн? Биеийн тамир, спортын салбарын эрдэмтэн, судлаач Доржсүрэнгийн Жаргалсайхан нар оролцож байна.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “олон улсын” гэснийг хасаж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “улсын” гэсний өмнө нэмж, мөн заалтын “, тэмцээнийг санхүүжүүлэх журам батлах” гэснийг хасаж, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж, 10.1.7 дахь заалтын “байгууллага” гэсний дараа “биеийн тамир, спортын” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.9 дэх заалт нэмэх:

“10.1.9.улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах журам батлах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62.5 хувийн санал дэмжигдлээ.

5.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “хэрэгжилтийг зохион байгуулах,” гэснийг, 11.1.7 дахь заалтын “холбогдох бусад” гэснийг, 11.1.10 дахь заалтын “шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих,” гэснийг, мөн заалтын “хэрэгжилтийг” гэснийг, 11.1.11 дэх заалтын “энэ хуулийн 9.1.3-т заасныг

үндэслэн” гэснийг, мөн заалтын “үйл ажиллагаанд” гэснийг, 11.1.12 дахь заалтын “нэгдсэн бодлого” гэснийг, 11.1.13 дахь заалтын “ажилтан” гэснийг, 11.1.16 дахь заалтын “сургалтын орчныг сайжруулах зөвлөмж гаргах” гэснийг, 11.1.21 дэх заалтын “ажлыг зохион байгуулах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 11.1.10 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “журмын дагуу” гэж, 11.1.11 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 11.1.16 дахь заалтын “хэрэгжүүлэхэд” гэснийг “боловсруулахад санал өгөх” гэж, 11.1.19 дэх заалтын “ажлыг зохион байгуулах” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах;” гэж, 11.1.20 дэх заалтын “уралдаан тэмцээнд” гэснийг “наадамд” гэж, 11.3 дахь хэсгийн “нэгжтэй” гэснийг “салбар байгууллагатай” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 11.1.4, 11.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.хүн амын бие бялдрын түвшин тогтоох, сорилын үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлал, боловсруулах;

11.1.18.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хороо байгуулж ажиллах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх хуулийн этгээдийг байгуулах тухай шийдвэр гаргах” гэснийг хасаж, мөн заалтын “дэлхийн зэрэглэлийн” гэснийг “дэлхийн аварга шалгаруулах тэмцээн,” гэж, 12.1.6 дахь заалтын “аймаг, дүүргийн өсвөр үе, оюутны шигшээ багийн төсөв батлах” гэснийг “санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 12.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.5.аймаг, нийслэл, дүүргийн өсвөр үе, оюутны шигшээ багт нийслэл, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөв батлах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Орон нутгаас төсвийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн зүйлийг тодорхой болгосон юм байна.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үеийн шигшээ багт, нийслэлийн төсвөөс оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тийм, энэ юун дээр хараарай. Орон нутгийн төсвөөс нийслэлийн шигшээ багт, Нийслэлийн төсвөөс оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэгчихсэн юм байна тээ? Энийгээ та нар эцсийн найруулга дээрээ юу яагаарай. Ер нь гүйцээн боловсруулах чиглэл өгчихье дөө тэгэх үү? Хасчихлаа ч гэсэн наадах чинь гуравны хоёроор босгох болчихно шүү дээ.

Тэгвэл ингэе 7 дугаар зүйл дээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Бат-Эрдэнэ сайд энийгээ нэгтгээд юу яачихъя тиймээ. Нийцүүлчихье.

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.6, 14.1.7 дахь заалтын “ажилтан” гэсний өмнө “байгууллагын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн” гэснийг хасаж, 14.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.5.байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан ажилтантай байх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “мэргэжлийн” гэсний дараа “техникийн” гэж нэмж, мөн заалтын “боловсролын” гэснийг “ердийн болон эмчилгээний биеийн тамирын сургалтын” гэж, 16.1.2 дахь заалтын “гадуурх ажлын чиглэлийг тогтооход” гэснийг “бусад сургалт явуулахад” гэж, 16.2.6 дахь заалтын “ерөнхий эрдмийн хичээлийн сургалтын чанарын үнэлгээ хангасан суралцагчийг” гэснийг “суралцагчийн сурлагын үнэлгээг харгалзан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 16.1.4 дэх заалтын “асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх” гэснийг, 16.2.6 дахь заалтын “зохион байгуулагдаж байгаа” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 16.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.4.боловсролын байгууллага нь сургалтын хөтөлбөрөөс гадна спорт клубийн хэлбэрээр суралцагчдын дунд үйл ажиллагаа зохион байгуулж болно;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “чиглэлийн” гэснийг, 17.1.3 дахь заалтын “хамтран” гэснийг, 17.2.1 дэх заалтын “ажил” гэснийг, 17.2.2 дахь заалтын “физик” гэснийг тус тус хасаж, 17.2.2 дахь заалтын

“спортын ажилтны оролцоотойгоор зохион байгуулах” гэснийг “арга зүйчтэй хамтран ажиллах” гэж өөрчлөн, 17.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.2.хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад сэргээн засах тусламж, үйлчилгээ, эмчилгээний биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр хүний эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “түвшний” гэснийг болон “, тамирчинд зориулсан” гэснийг, 20.2 дахь хэсгийн “өөр өөрийн онцлогт тохирсон” гэснийг, 20.5 дахь хэсгийн “өөрийн төлөөлөгчийн газар,” гэснийг, 20.6 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн тухайн” гэснийг, 20.8.15 дахь заалтын “, дэмжлэг авах” гэснийг, 20.9 дэх хэсгийн “дэмжлэгийн хэмжээ,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 20.4 дэх хэсгийн “өөрийн онцлог байдал, үйл ажиллагааны чиглэлээр нэг спортын төрлийн нэг төлөөлөгчийн газар,” гэснийг “онцлогт тохирсон нэг төрлийн спортын” гэж, 20.9 дэх хэсгийн “дэлхийн зэрэглэлийн” гэснийг “дэлхийн аварга шалгаруулах” гэж, мөн хэсгийн “15” гэснийг “10” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.8.14 дэх заалт нэмэх:

“20.8.14.спортын төрлийн үйл ажиллагаа, сургалт, дасгалжуулалт, орчны стандартыг боловсруулах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрлийн” гэснийг, 21.4 дэх хэсгийн “15 хүртэлх хүүхэд тутамд нэг”

гэснийг тус тус хасаж, 21.3 дахь хэсгийн “эрүүл мэндийн байдалд” гэсний дараа “мэргэжлийн байгууллагын” гэж нэмж, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийн “үндэсний стандарт байхгүй” гэснийг “мөрдөх боломжгүй” гэж, 21.4 дэх хэсгийн “хангаж” гэснийг “хариуцан ажиллана” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Спортын клуб нь иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхлэн, сургалт, дасгалжуулалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, ёс зүйтэй, хүмүүнлэг, бүтээлч, эрүүл чийрэг иргэн бэлтгэх, эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “бололцоогоор хангах” гэсний дараа “тухайн сургуулийн” гэж нэмж, мөн зүйлийн 23.4, 23.5, 23.6, 23.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.4.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хууль болон энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн холбоотой гэрээ байгуулж, санхүүжүүлнэ.

23.5.Аймаг, дүүргийн Засаг дарга спортын 10-аас доошгүй төрлөөр өсвөр үеийн шигшээ багийг байгуулан, орон нутаг дахь спортын холбоотой хамтран сонгон шалгаруулж, орон нутгийн төсвөөс үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

23.6.Нийслэлийн Засаг дарга оюутны дэлхийн аварга, дэлхийн оюутны спортын наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох оюутны шигшээ багийг спортын 8-аас доошгүй төрлөөр байгуулж, санхүүжүүлнэ.

23.8. Ёс зүйн болон допингийн зөрчил гаргасан нь шигшээ багийг бүрдүүлж байгаа спортын холбоо, тамирчин, дасгалжуулагчийг санхүүжүүлэхгүй байх үндэслэл болно.”

56.4 хувиар санал дэмжигдлээ.

14. Төслийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 25.8 дахь хэсгийн дугаарыг 25.6 болгон “зохион байгуулагч” гэсний дараа “, спортын холбоо, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь” гэж, 25.7 дахь хэсгийн “тэмцээний үед” гэсний өмнө “Зохион байгуулагч, спортын холбоо” гэж тус тус нэмж, мөн заалтын “эрүүл мэндэд хохирол учирсан” гэсний хасаж, 25.8 дахь хэсгийн “таслан зогсоох” гэснийг “гэнэтийн ослын даатгалд хамруулах, аюулгүй байдлыг хангах” гэж өөрчлөн, мөн зүйлийн 25.4, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.4. Энэ хуулийн 25.3-т заасан хуваарьт тусгагдаагүй спортын тэмцээнийг зохион байгуулагч тухайн сум, дүүрэг, хорооны биеийн тамирын арга зүйч, Биеийн тамир, спортын газарт ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

25.6. Энэ хуулийн 25.3, 25.4-т заасан спортын тэмцээнийг урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд зохион байгуулахыг хориглоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

15. Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “чиг үүргийг” гэсний дараа “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.4, 27.1.5 дахь заалт, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8 дахь хэсэг тус тус нэмэх:

“27.1.4. Допингийн эсрэг үндэсний зөвлөл;

27.1.5. Монголын олон улсын ба үндэсний спортын арбитр;

27.4. Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу Монголын үндэсний олимпын хороо Допингийн эсрэг үндэсний байгууллагыг үүсгэн байгуулах эрхтэй.

27.5. Допингийн эсрэг үндэсний байгууллагын удирдах зөвлөл нь 13 хүртэл тооны сондгой гишүүнтэй байх бөгөөд Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хороо, биеийн тамир, спортын салбарын төрийн байгууллага, спортын холбоо, тамирчдын зөвлөл, хуульчдын холбоо, эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

27.6. Допингийн эсрэг үндэсний байгууллага нь Дэлхийн допингийн эсрэг агентлагийн Допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлын тухай удирдамжийн холбогдох заалт, Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн¹ дагуу ил тод байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана.

27.7. Допингийн эсрэг үндэсний байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаатай нэг удаа сонгоно.

27.8. Монгол Улсын Засгийн газар Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцын дагуу хүлээсэн үүргээ энэ хуулийн 27.1.4-т заасан Допингийн эсрэг үндэсний зөвлөлөөр төлөөлүүлэн хэрэгжүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

16. Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “27.4” гэснийг “27.3” гэж өөрчлөн, мөн зүйлийн 28.3.2 дахь

заалтын “нэр дэвшигчийг” гэсний дараа “Дэлхийн допингийн эсрэг агентлагийн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.2 дахь хэсэг нэмэх:

“28.2.Допингийн эсрэг үндэсний байгууллагын үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлсэн, эсхүл татан буугдсан бол энэ тухай Дэлхийн допингийн эсрэг агентлагт мэдэгдэж, тус байгууллагыг шинэчлэх, дахин шинээр байгуулах хүртэл түүний үүргийг Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрмийн дагуу Монголын үндэсний олимпын хороо түр орлон гүйцэтгэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “Пара спорт, дүлий иргэдийн спорт, оюун ухааны” гэснийг хасаж, мөн хэсгийн “холбоо,” гэсний дараа “спорт клуб” гэж нэмж, мөн зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Хөгжлийн бэрхиээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэмжлэг үзүүлнэ.”. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалтын “бие сэтгэцийн хөгжилд тодорхойлолт” гэснийг “бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн онцлогт үнэлэлт, дүгнэлт” гэж өөрчилж, мөн зүйлийн 31.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах болон мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4.8 дахь заалт нэмэх:

“31.2.Дасгалжуулагч энэ хуулийн 9.1.5-д заасан журмын дагуу олгогдсон мөнгөн шагнал хүртсэн тамирчны

мөнгөн урамшууллаас талуудын гэрээний дагуу тодорхой хувь хүртэнэ.

31.4.8.допингийн талаарх мэдлэг, мэдээллээ байнга шинэчлэх, суралцагч, тамирчдад допинг хэрэглэхгүй байхыг зөвлөх, допингийн эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “хөдөлмөрийн” гэсний дараа “хүнд” гэж нэмж, мөн заалтын “гүйцэтгэсэн хөдөлмөрийн чанар, хэмжээнд” гэснийг “ажил үүрэгтээ” гэж өөрчилж, 33.3 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 33.2.2, 33.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.2.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдал, долоо хоногийн амралтын өдөр ажиллаж, нөхөн амруулаагүй бол Хөдөлмөрийн тухай хуулийн 109.2-т заасан нэмэгдэл цалин хөлсийг олгох, бусад урамшуулал, дэмжлэг үзүүлэх;

33.2.3.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн биеийн тамир, спортын байгууллагын биеийн тамир спортын ажилтан, арга зүйч, дасгалжуулагчид 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “22.3,” гэснийг “, 22.3-т заасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Спортыг дэмжих сангаас” гэж, 34.6 дахь хэсгийн “төсөвт

бие даасан зүйл болгон батална” гэснийг “төсвөөс” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “спортын” гэсний өмнө “Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж нэмж, 37.7 дахь хэсгийн “ажиллуулах” гэснийг “хадгалах, хамгаалах, ашиглах, түгээх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “хяналтын” гэсний дараа “үйл ажиллагааг” гэж, 39.3 дахь хэсгийн “тохиролцсон,” гэсний дараа “эсхүл спортын холбоод, тамирчин, дасгалжуулагч, сонирхогч этгээд хүсэлт гаргасан бол” гэж, мөн хэсгийн “холбоотой” гэсний дараа “аливаа” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 39.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.2 дахь хэсэг нэмэх.

“40.2.Олимп, тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн этгээд эрүүгийн хариуцлага хүлээсэн бол сар бүрийн мөнгөн урамшууллыг ял шийтгэл эдлэх хугацаанд нь олгохыг зогсооно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“41.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцье.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.8.спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих, олон улсын спортын холбооны стандартад нийцсэн, олимп, тив дэлхийн тэмцээн зохион байгуулах, спортын барилга байгууламжийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд өгсөн 100 сая хүртэлх төгрөгийн хандив;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “40.7” гэснийг “40.10” болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн гарчгийн “**ӨӨРЧЛӨЛТ**” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасаж, 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тийм, 5 жилийн хугацаанд л чөлөөлж байгаа юм байна. Хугацаатайгаар чөлөөлж байгаа гэсэн үг.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хичээллэх” гэсний дараа “идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг харгалзан магадлан итгэмжлэгдсэн спортын клубт үйлчилгээний төлбөрийн

дэмжлэг үзүүлэх” гэж нэмсүгэй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ нөгөө фитнес юм уу тээ? Төлбөрт нь дэмжлэг үзүүлэх гэсэн тийм заалт байна. Тийм, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэсэн иргэний үр дүнг үндэслээд үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлье гэж байгаа юм байна.

Дэмжигдсэнгүй энэ санал. Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин горимын санал гаргая.

Т.Энхтүвшин: Би уул нь дэмжсэн. Тэгээд энэ төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас санал хураалтыг дахиж явуулж өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшиний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Нэг. Үндсэн санал хураалтаа явуулъя. Уг санал хураалтыг хүчингүйд тооцсон. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн гарчигт **“БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ”** гэж нэмж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй санал байна.

Биеийн тамир спортын тухай хуулийн төсөл дээр санал байна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.19. “спортын барилга байгууламж” гэж олон улсын спортын холбооны дүрэм, стандартад нийцсэн олимп, тив, дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан орчин, хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий спортын зориулалтын барилга байгууламж, түүний дэд бүтцийг;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа гэсэн байна.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.33 дахь заалт нэмэх:

“4.1.33.спортын танхим” гэж иргэн, тамирчин биеийн тамир, спортоор хичээллэх, бэлтгэл хийх, спортын тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий байгууламж, түүний дэд бүтцийг.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа гэсэн байна. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.8.спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 100 сая хүртэлх төгрөгийн, олон улсын спортын холбооны дүрэм, стандартад олимп, тив, дэлхийн тэмцээн зохион байгуулах шаардлага хангасан спортын зориулалтын барилга байгууламж, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад тухайн татварын жилд өгсөн 10 хүртэлх тэрбум төгрөгийн хандив, тусламж;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

*Өнөөдрийн чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан
тул Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн
хуралдааныг өндөрлүүлж байна.*

19.25 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*